ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал сумын  ЗДТГ-ын  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/37/СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа
Утас:99080797
Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ...................................................... 3

3. Аудитын тайлан..........................................................................................................10

3.1 Ерөнхий зүйл..........................................................................................................10

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .................................................................10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................................................10

3.4 Материаллаг байдал ..................................................................................................11

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ................................................................................11

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..................................................................11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.........................................................12

3.8 Аудитын гол асуудал .................................................................................................12

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......................12

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...................................................................................13

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................................................13

4. Аудитын илрүүлэлт ....................................................................................................13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ......................................................................15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/396.

танай____________-ны №____________-т

УРГАМАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ӨСӨХБАЯР-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Ургамал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*Ажилтнуудад 2.7 сая төгрөгийн цалин, цалингийн нэмэгдэл, 0.1 сая төгрөгийн албан томилолтын зардал зэргийг илүү тооцож олгосон, түлш, халаалтын зардлын хэмнэлтээс 3.8 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгосон, баяр ёслолын үйл ажиллагаанд 0.5 сая төгрөгийг зарцуулсан, өмнөх жилд худалдан авсан 1.6 сая төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг ашиглаагүй зэрэг зөрчил илэрсэн нь* (Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.9; 40 дүгээр зүйлийн 40.4.2,41 дүгээр зүйлийн 41.2.2; Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалт зэрэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй) *байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

01202F438

| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | | | |
|---|---|---|---|
| **Дансны код** | **Балансын үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **15812032.68** | **21215365.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | 98678.20 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 98678.20 | 0.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 98678.20 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 15713354.48 | 21215365.48 |
| **354** | **Хангамжийн материал** | 15713354.48 | 21215365.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1308675.00 | 2385875.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11404079.48 | 14690179.48 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 781000.00 | 1290000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 606211.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2219600.00 | 2243100.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **209792216.14** | **200056563.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 209792216.14 | 200056563.83 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 205471716.14 | 196066063.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 518736681.08 | 534936681.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -457048622.93 | -461310790.97 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 97959800.00 | 97959800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -71017161.72 | -76071056.88 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 261896792.66 | 261896792.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -185111769.44 | -193778945.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17768367.20 | 17768367.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12455323.20 | -13620580.69 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 89446250.15 | 89446250.15 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -56091997.66 | -62549153.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 1388700.00 | 1388700.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4320500.00 | 3990500.00 |
| 39301 | Програм хангамж | 2802000.00 | 2802000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1179500.00 | -1509500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2698000.00 | 2698000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **225604248.82** | **221271929.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **487300.00** | **2092794.62** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 487300.00 | 2092794.62 |
| **413** | **Өглөг** | 487300.00 | 2092794.62 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 2092794.62 |
| **4136** | **Бусад өглөг** | 487300.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 56500.00 | 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 430800.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **225116948.82** | **219179134.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 225116948.82 | 219179134.69 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 359126865.33 | 359126865.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 359126865.33 | 359126865.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -319961184.40 | -325898998.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -319961184.40 | -319961184.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -5937814.13 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 185951267.89 | 185951267.89 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **225604248.82** | **221271929.31** |

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **338751625.00** | **412237590.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9387567.00** | **16200000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9387567.00 | 16200000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9387567.00 | 16200000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9387567.00 | 16200000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **329364058.00** | **396037590.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 319838700.00 | 355626300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 319838700.00 | 355626300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1475610.00 | 40411290.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 40411290.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1475610.00 | 0.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 8049748.00 | 0.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2134410.00 | 0.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | | |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 3301050.00 | 0.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 2614288.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **352988502.57** | **418175404.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **352988502.57** | **393175404.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 330990869.57 | 354284272.91 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206854138.00 | 209260926.85 |
| 210101 | Үндсэн цалин | 206854138.00 | 192687186.43 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 16573740.42 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26946677.01 | 30451343.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18878610.01 | 18952545.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1654833.00 | 5280370.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2068541.00 | 1771422.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394970.00 | 404273.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3949723.00 | 4042733.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35912274.00 | 48385991.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2765417.00 | 2866604.04 |
| 210302 | Түлш, халаалт | 33146857.00 | 45519387.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16311570.00 | 14856559.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2184615.00 | 1663420.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10598955.00 | 9918789.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2665500.00 | 3074400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 862500.00 | 199950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1323500.00 | 554750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 93000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1230500.00 | 554750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1738800.00 | 2921200.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1738800.00 | 2921200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8490127.24 | 3807728.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7170670.24 | 3002058.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 570600.00 | 144000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 195350.00 | 163350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195420.00 | 156620.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73800.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150000.00 | 203400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 118587.00 | 138300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15700.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33413783.32 | 44045774.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7826500.00 | 18000000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 528400.00 | 110122.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25058883.32 | 25935652.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21997633.00 | 38891131.22 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200000.00 | 27335300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 27335300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 21797633.00 | 9943212.48 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21797633.00 | 9943212.48 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.00 | 1612618.74 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 1612618.74 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **25000000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 25000000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 25000000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-14236877.57** | **-5937814.13** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6698236.21 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 6698236.21 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -6698236.21 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-20935113.78** | **-5937814.13** |

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **329364058.00** | **396037590.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **329364058.00** | **396037590.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 319838700.00 | 355626300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 319838700.00 | 355626300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1475610.00 | 40411290.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 40411290.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1475610.00 | 0.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 8049748.00 | 0.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2134410.00 | 0.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | | |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 3301050.00 | 0.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 2614288.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **327714058.00** | **371037590.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **327714058.00** | **371037590.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **305716425.00** | **332146458.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 206854138.00 | 209260926.85 |
| 210101 | Үндсэн цалин | 189817308.00 | 192687186.43 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17036830.00 | 16573740.42 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27169365.76 | 28253824.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19101298.76 | 20277317.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1654833.00 | 2072284.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2068541.00 | 1631596.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394970.00 | 388420.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3949723.00 | 3884206.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35562274.00 | 48385991.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2765417.00 | 2866604.04 |
| 210302 | Түлш, халаалт | 32796857.00 | 45519387.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16554120.00 | 16252970.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2483665.00 | 2624120.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10598955.00 | 9948600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2665500.00 | 3074400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 806000.00 | 605850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1423500.00 | 1033150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 93000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1330500.00 | 1033150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1308000.00 | 3352000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1308000.00 | 3352000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8490127.24 | 5304874.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7170670.24 | 4499204.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 570600.00 | 144000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 195350.00 | 163350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195420.00 | 156620.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73800.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150000.00 | 203400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 118587.00 | 138300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15700.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8354900.00 | 20302722.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7826500.00 | 20000000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 528400.00 | 302722.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21997633.00** | **38891131.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200000.00 | 27335300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 27335300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 21797633.00 | 9943212.48 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21797633.00 | 9943212.48 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.00 | 1612618.74 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 1612618.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1650000.00** | **25000000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **25000000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **25000000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 25000000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-25000000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 1650000.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 359,126,865.33 | 185,951,267.89 | -299,026,070.62 | 0.00 | 246,052,062.60 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **359,126,865.33** | **185,951,267.89** | **-299,026,070.62** | **0.00** | 246,052,062.60 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -20,935,113.78 | 0.00 | -20,935,113.78 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **359,126,865.33** | **185,951,267.89** | **-319,961,184.40** | **0.00** | 225,116,948.82 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **359,126,865.33** | **185,951,267.89** | **-319,961,184.40** | **0.00** | 225,116,948.82 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **359,126,865.33** | **185,951,267.89** | **-319,961,184.40** | **0.00** | 225,116,948.82 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 359,126,865.33 | 185,951,267.89 | -319,961,184.40 | 0.00 | 225,116,948.82 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **718,253,730.66** | **371,902,535.78** | **-639,922,368.80** | **0.00** | 450,233,897.64 |

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 325738700.00 | 299373937.00 | 355094200.00 | 350117627.78 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 325738700.00 | 299373937.00 | 355094200.00 | 350117627.78 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 325738700.00 | 299373937.00 | 327758900.00 | 322782327.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 213521700.00 | 206854138.00 | 218021700.00 | 209260926.85 |
| 210101 | Үндсэн цалин | 195856800.00 | 189817308.00 | 200356800.00 | 192687186.43 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17664900.00 | 17036830.00 | 17664900.00 | 16573740.42 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29432900.00 | 27169365.76 | 29432900.00 | 28253824.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20712100.00 | 19101298.76 | 20712100.00 | 20277317.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2180200.00 | 1654833.00 | 2180200.00 | 2072284.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1744200.00 | 2068541.00 | 1744200.00 | 1631596.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 436000.00 | 394970.00 | 436000.00 | 388420.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4360400.00 | 3949723.00 | 4360400.00 | 3884206.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48369500.00 | 35562274.00 | 48369500.00 | 47967814.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2861700.00 | 2765417.00 | 2861700.00 | 2448427.04 |
| 210302 | Түлш, халаалт | 45507800.00 | 32796857.00 | 45507800.00 | 45519387.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15697300.00 | 15097765.00 | 13717500.00 | 15697270.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2632900.00 | 2483665.00 | 2303800.00 | 2624120.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9948600.00 | 9948600.00 | 8705400.00 | 9948600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3115800.00 | 2665500.00 | 2708300.00 | 3074400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1000000.00 | 639500.00 | 700000.00 | 1000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1000000.00 | 639500.00 | 700000.00 | 1000000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3353800.00 | 1308000.00 | 3353800.00 | 3352000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3353800.00 | 1308000.00 | 3353800.00 | 3352000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5560100.00 | 4612994.24 | 2360100.00 | 1947770.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2400000.00 | 1982037.24 | 1000000.00 | 1142100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232100.00 | 232100.00 | 232100.00 | 144000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469100.00 | 195350.00 | 469100.00 | 163350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227700.00 | 195420.00 | 227700.00 | 156620.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73800.00 | 73800.00 | 73800.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2003400.00 | 1800000.00 | 203400.00 | 203400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138300.00 | 118587.00 | 138300.00 | 138300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15700.00 | 15700.00 | 15700.00 | 0.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8803400.00 | 8129900.00 | 11803400.00 | 15302722.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8500000.00 | 7826500.00 | 11500000.00 | 15000000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303400.00 | 303400.00 | 303400.00 | 302722.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 27335300.00 | 27335300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 | 27335300.00 | 27335300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.0 | 0.0 | 27335300.00 | 27335300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 325738700.00 | 319838700.00 | 22243427949.00 | 355626300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 325738700.00 | 319838700.00 | 22243427949.00 | 355626300.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 325738700.0 | 319838700.0 | 22243427949.00 | 355626300.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **20464763.0** | 0.00 | 5508672.22 |

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **34364131.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **9364131.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 9364131.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 418177.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 418,177.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 555700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 555,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 33150.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 33,150.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 3357104.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 3,357,104.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 5000000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **25000000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 25000000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 25,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 40411290.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 40411290.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 40,411,290.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ургамал сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Д,Пүүжмаа ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Ургамал сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ургамал сумын ЗДТГ нь иргэдээ сонсож,тэдний эрх ашгийг дээдлэн, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд иргэн бүрд ил тод хөнгөн шуурхай , тэгш хүртээмжтэй хүргэж ажиллах гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 412.237,6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4.186,0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (70 хувиар) буюу 2.930,2 мянга төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 98,6 | 0 | -98,6 |
| Бараа материал | 15,713.3 | 21.215,3 | 5.502,0 |
| Үндсэн хөрөнгө | 209.792,2 | 200.056,5 | -9.735,7 |
| **Нийт хөрөнгө** | 225.604,2 | 221.271,9 | -4.332,3 |
| Өр төлбөр | 487,3 | 2.092,8 | 1.605,5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 225.604,2 | 221.271,9 | -4.332,3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 225.604,2 | 221.271,9 | -4.332,3 |

Авлага дансны үлдэгдэл 98,6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажилчидтай холбоотой авлага барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.502,0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9.735,7 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.605,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны аж ахуйн нэгжид өгөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4.332,3 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 354,280.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 354,280.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 355.626,3 мянган төгрөгийн, санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 350.117,7 мянган төгрөгийг зарцуулж, 5.508,6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 40.411,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос үйл ажиллагааны 34.364,2 мянган төгрөгийг зарцуулж 6.047,1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Цалингийн зардлаас олгосон урамшуулал, нэмэгдэл цалин, тэтгэмж урамшууллыг буруу тооцоолон олгосон, ХЧТА-ны тэтгэмжийг цалинтай давхардуулан олгосон, ковидын зардалд олгосон мөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна..

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна   гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн нэмэгдэл, урамшууллыг олгохдоо хууль, дүрэм журмыг биелүүлэн ажиллаж, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт  23.051,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.986,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4.504,8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч, 3.799,0 мянган төгрөгийн алдаанд албан шаардлага хүргүүлж,2.760,8 мянган төгрөгийн алдаанд төлбөрийн акт тогтоолоо.

### 4.1 Залруулсан алдаа

Төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан, өмнөх оны өглөгийг тайлант онд хаасан боловч өглөгөө санхүүгийн  тайланд хааж бүртгээгүй 11.986,6 мянган төгрөгийн алдааг залруууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

*1.1. Илрүүлэлт:*

- ✓ *Тамгын газрын даргын үр дүнгийн гэрээг сумын Засаг дарга хангалтгүй үнэлгээтэй дүгнэж үр дүнгийн урамшууллыг 30 хувиар бодож 365,9 мянган төгрөгийг цалин дээрээ тооцон авсан*
- ✓ *Сумын Засаг даргад 120,0 мянган төгрөгийн томилолтын мөнгийг илүү тооцон олгосон*
- ✓ *Цалин, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн 518,2 мянган төгрөгийг давхардуулан олгосон*
- ✓ *Босоо тогтолцоотой байгууллагын албан хаагчдад цалингийн сангаас 1,333,7 мянган төгрөгийн урамшуулал олгосон*

- ✓ *Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 422,9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон*

*1.2 Шийдвэрлэлт*

*✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3, 4.2.3.8 дахь заалтуудыг үндэслэн дээр гаргасан алдааг төсөвт эргэн төлүүлэхээр 2.760,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.*

### 4.3 Албан шаардлага

*1.1. Илрүүлэлт:*

*✓ Түлш халаалтын хэмнэгдсэн зардлаас ажилчдадаа 3.799,0 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон*

*1.2 Шийдвэрлэлт*

*✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3, 4.2.3.8 дахь заалтуудыг үндэслэн Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын дагуу батлагдсан төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллахыг шаардаж 3.799,0 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүлсэн.*

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *1.650,0 мянган төгрөгийн үнэтэй 2020 онд худалдан авсан Си-Ти-Эс ХХК-ний нягтлан бодох бүртгэлийн болон нярвын программыг 2021 онд ашиглаагүй.*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн болон нярвын программыг ашиглан хагас жилийн тайланг бэлтгэж гаргах*

***2. Арвилан хэмнэлттэй холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *Аймгийн Засаг даргаас ковидын зардалд олгосон мөнгөнөөс 2354.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан*
- ✓ *Хөл хорионы дэглэмтэй байгаа үед баяр тэмдэглэхэд зориулж тушаалаар 500,0 мянган төгрөгийн зардал гаргаасан*

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

- ✓ *Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>1.</td><td>Ургамал сумын ЗДТГ</td><td>7</td><td>23,0</td><td>2</td><td>11,9</td><td>1</td><td>2,7</td><td>1</td><td>3,8</td><td>3</td><td>4,5</td></tr>
</table>